



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ  
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠦᠭᠢᠨ  
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ  
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

**МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2021 оны 06 сарын 04 өдөр

Дугаар А/241

Алтай хот

Комисс томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6 дахь заалт, 37 дугаар зүйлийн 37.1.6 дахь заалт, Засгийн газрын 2018 оны “Дүрэм шинэчлэн батлах тухай” 317 дугаар тогтоол, Барилга, хот байгуулалтын сайдын 2018 оны 218 дугаар тушаалаар батлагдсан “Барилга байгууламжийн төвөгшлийн ангиллыг зориулалт, хүчин чадлаар нь тогтоох дүрэм”, 2020 оны “Зөвлөмж батлах тухай” 229 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Есөнбулаг сумын Наран багийн нутаг дэвсгэрт хэрэгжиж буй “Хан Алтай” алтны ордны төслийн хүрээнд хийгдсэн 35 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцын угсралтын ажлыг хүлээн авч, ашиглалтад оруулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.


Комиссын дарга:	Б.Бямбадорж	-(Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга бөгөөд аймгийн Ерөнхий архитектор)
Гишүүдэд:	М.Мандаххүү	-(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Архивын тасгийн дарга)
	Ж.Мөнхчимэг	-(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалт, нийтийн аж ахуйн хөгжлийн бодлого төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн)
	Ц.Амарсанаа	-(Онцгой байдлын газрын гал түймрийн улсын хяналтын байцаагч, хошууч)
	Д.Отгонжаргал	-(Мэргэжлийн хяналтын газрын эрчим хүчний хяналтын улсын байцаагч)

2.

- Д.Чинзориг -(Есөнбулаг сумын Засаг дарга)  
М.Туул -(Есөнбулаг сумын Засаг даргын  
Тамгын газрын Захирагчийн  
албаны ахлах мэргэжилтэн)  
Б.Бээжин -("Алтай-Улиастайн эрчим хүчний  
систем" ТӨХК-ийн үйлдвэрлэл  
эрхэлсэн дэд захирал бөгөөд  
ерөнхий инженер)  
Ц.Бямбатогтох -("Хан Алтай ресурс" ХХК-ийн эрчим  
хүчний ахлах зөвлөх) (захиалагч)  
Ц.Мижиддорж -("Хан Алтай ресурс" ХХК-ийн  
цахилгааны инженер) (захиалагч)  
Г.Бат-Эрдэнэ -("Ричвелл Инженеринг" ХХК-ийн  
цахилгааны инженер)  
Д.Батжав -("Энх өглөө" ХХК-ийн дэд захирал)  
(гүйцэтгэгч)  
Нарийн бичгийн дарга:М.Мөнхцэцэг -(Газрын харилцаа, барилга, хот  
байгуулалтын газрын инженерийн  
барилга байгууламж хариуцсан  
мэргэжилтэн)

2.Барилга угсралтын ажлыг байнгын ашиглалтад оруулахдаа гэрээнд тусгагдсан техникийн нөхцөл, зураг төсөл, холбогдох баримт бичгийн бүрдлийг хүлээн авч, үр дүнг танилцуулахыг комисс (Б.Бямбадорж)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР